



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Албан журмын даатгагчдын холбооны
Удирдах зөвлөлийн даргыг өөрчлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12¹.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Гаравдэмбэрэлийн Хэрлэнг чөлөөлж, уг үүрэгт ажилд Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн Эрдэнэбилэгийн Батболдыг томилсугай.

2. Албан журмын даатгагчдын холбооны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтыг судалж, санал боловсруулан Хорооны хуралдаанд 2015 оны 2 дугаар сард багтаан танилцуулж шийдвэрлүүлэхийг тус Холбооны Удирдах зөвлөл /Э.Батболд/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000615